

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... ний өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн зүйл, заалтыг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

1/Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дараах 16¹ дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“16¹.1.Улсын Их Хурлаас Монгол Улсын нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангуулах үүрэг бүхий хараат бус, бие даасан, байнгын ажиллагаатай Төсвийн тогтвортой байдлын зөвлөл/цаашид “Зөвлөл” гэх/-ийг байгуулна.

16¹.2.Зөвлөл үйл ажиллагаандаа бие даасан, ил тод байх, бусдын нөлөөнд үл автах, төсвийн тогтвортой байдлыг хангах, нийтийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хамтын удирдлагын зарчмаар асуудлыг чөлөөтэй хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэх зарчмыг удирдлага болгоно.

16¹.3.Зөвлөл нь орон тооны 7 гишүүнээс бүрдэх бөгөөд Төсвийн байнгын хороо нэр дэвшигчийг нээлттэй сонгон шалгаруулалтаар шалгаруулан, сонсгол хийсний дагуу Зөвлөлийн гишүүдийг Улсын Их Хурал 4 жилийн хугацаагаар томилно.

16¹.4.Төсвийн тогтвортой байдлыг хангахад Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16¹.4.1.дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл боловсруулахад баримтлах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалыг боловсруулах;

16¹.4.2.Монгол Улсын жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийцсэн эсэх талаар дүгнэлт, зөвлөмж өгөх;

16¹.4.3.Төсвийн байнгын хороо хүсэлт гаргасан бол хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийн улсын төсөвт нөлөөлөл, ачаалал үзүүлэх эсэх талаар шинжилгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах;

16¹.4.4.төсөв, санхүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал гаргах, Улсын Их Хуралд танилцуулах;

16¹.4.5.Зөвлөл чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, судалгааг Улсын Их Хурал, Засгийн газар, Монголбанк, Үндэсний статистикийн хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл, Эдийн засаг, хөгжлийн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, холбогдох бусад төрийн байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагаас гаргуулан авах;

16¹.4.6.шаардлагатай гэж үзвэл Зөвлөлөөс гаргасан дүгнэлт, зөвлөмжийн талаар Засгийн газраас холбогдох тайлбарыг гаргуулж авах.

16¹.5.Зөвлөл төсвийн дунд хугацааны таамаглалын тайлан, төсвийн тогтвортой байдлын болон эрсдэлийн тайлан, бодлогын нөлөөллийн шинжилгээний тайланг гаргаж хуралдаанаараа хэлэлцэн, Улсын Их Хуралд танилцуулж, нийтэд мэдээлэх ба хагас жил тутам олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулна.

16¹.6.Зөвлөл шаардлагатай тохиолдолд холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн, төв, их, дээд сургууль, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагаар судалгаа, шинжилгээний ажил хийлгэж болно.

16¹.7.Зөвлөлийн дарга, гишүүн нь дараах шаардлагыг хангасан байна:

16¹.7.1.эдийн засаг, санхүүгийн чиглэлээр магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх;

16¹.7.2.сүүлийн зургаан жилийн хугацаанд улс төрийн намын гишүүнчлэлгүй, улс төрийн үйл ажиллагаа явуулаагүй байх;

16¹.7.3.зөвлөлийн гишүүнээс чөлөөлөгдсөнөөс хойш 6 жилийн хугацаанд аливаа сонгуульд нэр дэвшихгүй байх;

16¹.7.4.зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хугацаа хэтэрсэн өргүй байх;

16¹.7.5.хувь хүний ёс зүй болон нэр хүнд нь Зөвлөлийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх;

16¹.7.6.эдийн засаг, санхүүгийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж, олон улсад нэр хүнд бүхий эрдэм, шинжилгээ судалгааны сэтгүүлд нийтлүүлсэн байх, эсхүл эдийн засаг, төсөв, мөнгөний бодлого, санхүү, татварын чиглэлээр мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх.

16¹.8.Зөвлөлийн дарга, гишүүнийг сонгон шалгаруулах, томилоход дараах журмыг баримтална:

16¹.8.1.Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо 45-аас доошгүй хоногийн өмнө Зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах тухай зарыг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд мэдээлэх;

16¹.8.2.энэ хуулийн 16¹.7-д заасан шаардлагыг хангасан иргэн сонгон шалгаруулалтын зар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлагдсанаас хойш 30 хоногийн дотор нэр дэвших хүсэлтээ Төсвийн байнгын хороонд ирүүлэх;

16¹.8.3.Төсвийн байнгын хороо ажлын хэсэг байгуулж, энэ хуулийн 16¹.8.1-т заасан хугацаанд багтаан сонгон шалгаруулалтыг зохион байгуулах;

16¹.8.4.ажлын хэсэг сонгон шалгаруулалтын үр дүнд хамгийн өндөр үнэлгээ авсан иргэнийг Зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлж томилох саналаа Төсвийн байнгын хороонд хүргүүлэх;

16¹.8.5.Төсвийн байнгын хороо нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29, 30, 31 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 123-127 дугаар зүйлд заасны дагуу нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулах.

16¹.8.6.Зөвлөлийн гишүүд нь даргаа олонхын саналаар 2 жилийн хугацаагаар сонгож, чөлөөлнө. Зөвлөлийн даргыг нэг удаа улируулан сонгож болно.

16¹.9.Зөвлөлийн гишүүнийг дараах тохиолдолд хугацаанаас нь өмнө Улсын Их Хурал чөлөөлнө:

16¹.9.1.өөр ажилд томилогдон ажиллах болсон;

16¹.9.2.өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлт гаргасан;

16¹.9.3.хуульд өөрөөр заагаагүй бол төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн;

16¹.9.4. гэмт хэрэг үйлдсэн болох нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор батлагдсан;

16¹.9.5.Зөвлөлийн гишүүн хуульд заасан чиг үүргээ удаа дараа биелүүлээгүй;

16¹.9.6.бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад олж мэдсэн төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний хувийн мэдээлэлд хамаарах мэдээллийг задруулах, хувьдаа ашигласан;

16¹.9.7.энэ хуулийн 16¹.7.4, 16¹.7.5, 16¹.18-т заасан шаардлагыг зөрчсөн;

16¹.9.8.эрх зүйн чадамжгүй болох нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон;

16¹.9.9.хуульд заасан бусад үндэслэл.

16¹.10.Зөвлөл энэ хуулийн 16¹.4-т заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, мэдээлэл, нэгдсэн зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий ажлын алба нь Улсын Их Хурлын Тамгын газрын бүтцэд хамаарна. Ажлын албаны орон тоо, бүтцийг Улсын Их Хурлын Тамгын газар батална.

16¹.11.Зөвлөлийн төсөвтэй холбоотой судалгаа, шинжилгээ хийхэд дэмжлэг үзүүлэх, туслах чиг үүрэг бүхий 7 орон тоотой төсвийн судалгааны нэгжийг Зөвлөлийн харьяанд ажиллуулна. Судалгааны нэгжийн албан тушаалтныг Зөвлөлийн саналыг харгалзан Улсын Их Хурлын Тамгын Газар томилж, чөлөөлнө.

16¹.12.Зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг Зөвлөлийн саналыг үндэслэн Улсын Их Хурлын төсөвт тусгана.

16¹.13.Зөвлөлийн шийдвэр нь дүгнэлт, зөвлөмж хэлбэртэй байна.

16¹.14.Зөвлөлийн дүрмийг Улсын Их Хурал батална.

16¹.15.Зөвлөл үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд жил бүр тайлагнана.

16¹.16.Зөвлөлийн гишүүний албан тушаалын зэрэг зиндаа, цалин хөлсийг Улсын Их Хурал тогтооно. Зөвлөлийн дарга, гишүүдийн цалин хөлс нь албан тушаалын цалин болон төрийн алба хаасан хугацааны, докторын зэргийн нэмэгдлээс бүрдэнэ;

16¹.17.Зөвлөлийн гишүүнийг энэ хуулийн 16¹.9-д зааснаас бусад тохиолдолд үүрэгт ажлаас нь чөлөөлөхийг хориглоно;

16¹.18.Зөвлөлийн дарга, гишүүн нь төсвийн байгууллагад шууд болон шууд бус хэлбэрээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх, өөр ажил, албан тушаал хавсран эрхлэхийг хориглоно.”

2/Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалт:

“6.1.4.Засгийн газрын өрийн нэрлэсэн үнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх.”

2 дугаар зүйл.Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтын “эсхүл” гэснийг “урсгал тэнцэл” гэж, “6.4” гэснийг “6.2” гэж, “6.5” гэснийг “6.3” гэж, 6.3 дахь хэсгийн “6.4” гэснийг “6.2” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 50 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 50.4 дэх хэсэг нэмсүгэй:

1/50 дугаар зүйлийн 50.4 дэх хэсэг:

“50.4.Улсын Их Хурлын төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөвтөө багтаан Тогтвортой байдлын зөвлөлийн даргын саналаар Тогтвортой байдлын зөвлөлийн зардлыг санхүүжүүлнэ.”

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг:

“48.1.Улсын Их Хурлын төсөв нь гишүүд, Байнгын хороод, хянан шалгах түр хороо, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, нам, эвслийн бүлэг, Тамгын газар, Улсын Их Хурлын нийтлэг арга хэмжээний төсвөөс тус тус бүрдэнэ.”

3 дугаар зүйл. Энэ хуулийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 112.2.16 дахь заалт нэмсүгэй:

1/112 дугаар зүйлийн 112.2.16 дахь заалт:

“112.2.16.Хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийн талаарх Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тайланг Төсвийн байнгын хороонд жил бүр.”

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсгийн “байгууллагын” гэсний дараа “болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн”, 69.2 дахь хэсгийн “Ерөнхий аудитор” гэсний дараа “, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга тус тус” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Монгол улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.4 дэх хэсгийн “аудитораас” гэснийг “аудитор гэж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн даргаас” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ... ний өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дугаар зүйл. Төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх хэсгийн “Үндэсний” гэсний өмнө “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүн,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны .. сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

**ТӨРИЙН ӨНДӨР АЛБАН ТУШААЛТНЫ ЗЭРЭГ ЗИНДАА, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ
ТӨРИЙН АЛБАН ТУШААЛТНЫ ЗЭРЭГЛЭЛИЙГ ТОГТООХ ТУХАЙ**

ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ НЬ:

1.“Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 19 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэл”-ийн “Адилтгах албан тушаалын зэрэглэл”-ийн “ТӨ-VA”-ийн “Захиргааны албан тушаал”-д “Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн дарга” гэсний дараа “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга” гэж, “ТӨ-VIA”-ийн “Захиргааны албан тушаал”-д “Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн гишүүн” гэсний дараа “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн” гэж тус тус нэмсүгэй.

2.Энэ тогтоолыг 2024 оны ... дугаар сарын ..-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны ... дугаар сарын ...-ний өдөр Дугаар ...

Улаанбаатар хот

ТОГТООЛЫН ХАВСРАЛТЫГ ӨӨРЧЛӨН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹ дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

- Монгол Улсын Их Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэм”-ийг хавсралтаар өөрчлөн баталсугай.
- Энэ тогтоолыг 2024 оны ... дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ дүрмийн зорилго нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/-ийн зорилго, зорилт, чиг үүрэг, бүрэн эрх, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчмыг тодорхойлж, төсвийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр холбогдох байгууллага, олон нийттэй харилцах харилцааг зохицуулахад оршино.

1.2. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, эдгээр хуультай нийцсэн холбогдох бусад хууль тогтоомж болон энэ дүрмийг баримтална.

1.3. Зөвлөл үйл ажиллагаандаа бие даасан, ил тод байх, бусдын нөлөөнд үл автах, төсвийн тогтвортой байдлыг хангах, нийтийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хамтын удирдлагын зарчмаар асуудлыг чөлөөтэй хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэх зарчмыг удирдлага болгоно.

1.4. Зөвлөл эрхлэх асуудлынхаа онцлогийг илэрхийлсэн бэлгэдэлтэй байж болох бөгөөд тогтоосон журмын дагуу тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Зөвлөлийн чиг үүрэг, үйл ажиллагааны чиглэл

2.1. Зөвлөл дор дурдсан чиг үүргийг хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд дараах чиглэлээр хэрэгжүүлнэ.

2.1.1. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл боловсруулахад баримтлах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалыг боловсруулах чиглэлээр:

2.1.1.а. макро эдийн засгийн тооцооллын загварт суурилан эдийн засгийн болон төсвийн дунд хугацааны төсөөлөл, таамаглалыг боловсруулан тайланг олон нийтэд нээлттэй байршуулах;

2.1.1.б. макро эдийн засгийн болон төсвийн төсөөлөл гаргах загвар, аргачлалыг боловсруулах, хөгжүүлэх чиглэлд дотоод, гадаадын судлаачид, олон улсын болон төрийн байгууллагуудтай хамтран ажиллах;

2.1.1.в. эдийн засгийн болон төсвийн талаарх мэдээллийн сан бүрдүүлж шинжилгээ, үнэлгээ хийхэд ашиглах.

2.1.2. Төсвийн бодлогын баримт бичгийн төслүүдийг Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийцсэн эсэх талаар дүгнэлт, зөвлөмж өгөх чиглэлээр:

2.1.2.а. төсвийн тогтвортой байдлын болон төсвийн эрсдэлийн шинжилгээнд тулгуурлан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төсөлд дүгнэлт, зөвлөмж гаргах;

2.1.2.б. төсвийн орлого, зарлага, өрийн тогтвортой байдлын дүн шинжилгээнд ашиглах загвар боловсруулах;

2.1.2.в. төсвийн эрсдэлийг тодорхойлох, тоон утгаар илэрхийлэх чиглэлээр олон улсын болон дотоодын байгууллагуудтай хамтран ажиллах;

2.1.2.г. дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөлд өгсөн дүгнэлт, зөвлөмжийг олон нийтэд танилцуулах, хэлэлцүүлэх.

2.1.3. Төсвийн байнгын хороо санал, хүсэлт гаргасан бол хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийн улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл, ачааллын талаар шинжилгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах чиглэлээр:

2.1.3.а. төсөвт нөлөөлөхүйц томоохон бодлогын шийдвэрүүдийн нөлөөллийг тооцоолох загвар боловсруулах;

2.1.3.б. бодлогын нөлөөллийн шинжилгээнд үндэслэн хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл улсын төсөвт нөлөөлөл, ачаалал үзүүлэх эсэх талаар дүгнэлт, зөвлөмж гаргах.

2.2. Зөвлөл чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, судалгааг Улсын Их Хурал, Засгийн газар, Монголбанк, Үндэсний статистикийн хороо, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл, эдийн засаг, хөгжлийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, холбогдох бусад төрийн байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагаас гаргуулан авч ашиглана.

Гурав. Зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалт

3.1. Зөвлөл стратеги төлөвлөгөөтэй байна. Стратеги төлөвлөгөөний зорилтыг жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

3.2. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

3.3. Хуралдааны дэгийг Зөвлөл тогтооно.

3.4. Зөвлөлийн нийт гишүүдийн олонх нь хүрэлцэн ирсэн бол хуралдааныг хүчинтэйд тооцно.

3.5. Зөвлөлийн хуралдаанд шаардлагатай гэж үзвэл хөндлөнгийн шинжээч, мэргэжилтнүүдийг оролцуулан мэдээлэл авч болно.

3.6. Зөвлөлийн хуралдааны явцыг хуралдааны тэмдэглэлд нэг бүрчлэн тэмдэглэнэ.

3.7. Зөвлөлийн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэр гаргах бөгөөд түүнд Зөвлөлийн дарга болон хуралдаанд оролцсон гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна. Шийдвэрийн талаар тусгайлсан саналтай гишүүний саналыг хуралдааны тэмдэглэлд тусгана.

3.8. Зөвлөлийн шийдвэр нь дүгнэлт, зөвлөмж хэлбэртэй байна.

3.9. Хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд Зөвлөлийн дарга, гишүүд холбогдох хууль болон энэ дүрэмд нийтэд мэдээлэхээр заасан Зөвлөлийн шийдвэрийг танилцуулахад биечлэн оролцоно.

Дөрөв. Зөвлөлийн зохион байгуулалтын бүтэц

4.1. Зөвлөлийн төсөвтэй холбоотой судалгаа, шинжилгээ хийхэд дэмжлэг үзүүлэх, туслах чиг үүрэг бүхий судалгааны нэгж нь 7 орон тоотой байна. Судалгааны нэгжийн албан тушаалтныг Зөвлөлийн саналыг харгалзан Улсын Их Хурлын Тамгын Газар томилж, чөлөөлнө.

4.2. Зөвлөлийн гишүүдийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, мэдээлэл, нэгдсэн зохион байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий Ажлын алба ажиллана.

Тав. Зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрх

5.1. Зөвлөлийн дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

5.1.1. Зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

- 5.1.2. Зөвлөлийн төсөв, үйл ажиллагааны зардал, өмч хөрөнгөтэй холбоотой асуудлаар Улсын Их Хурлын Тамгын Газарт Зөвлөлийн саналыг хүргүүлэх, холбогдох шийдвэрийг гаргуулах;
- 5.1.3. Зөвлөлийг дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;
- 5.1.4. Зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулсан журмыг батлах;
- 5.1.5. Судалгааны нэгжийн ажилтнуудыг томилуулах саналыг Зөвлөлийн хуралдаанд оруулах;
- 5.1.6. Зөвлөлийг төлөөлөхдөө Зөвлөлийн шийдвэр, байр суурийг баримтлах;
- 5.1.7. Шаардлагатай тохиолдолд албан үүргээ Зөвлөлийн аль нэг гишүүнээр түр орлон гүйцэтгүүлэх.
- 5.2. Зөвлөлийн гишүүн дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:
 - 5.2.1. бүрэн эрхэд хамаарах асуудлаар санал боловсруулж, Зөвлөлийн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх;
 - 5.2.2. Зөвлөлийг хуралдуулах санал гаргах, шаардах;
 - 5.2.3. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан нэмэлт материал, мэдээллийг Судалгааны нэгж, Ажлын албанаас шаардах, танилцах, хэлэлцэж байгаа асуудлаар байр сууриа илэрхийлэх, хуралдааны тэмдэглэлд тусгуулах;
 - 5.2.4. Зөвлөлийн даргын түр эзгүйд түүний үүрэг болгосноор Зөвлөлийн даргыг орлон ажиллах;
 - 5.2.5. Төсвийн тогтвортой байдлыг хангах, төсвийн тусгай шаардлагыг мөрдөхтэй холбоотой судалгаа, шинжилгээ хийх, дүгнэлт, зөвлөмж өгөхдөө шударга, ашиг сонирхлоос ангид, улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй байх.

Зургаа. Зөвлөл бусад байгууллага, олон нийттэй харилцах

6.1. Зөвлөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹.1-д заасан хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээс хойш 20 хоногийн дотор судалгаа, шинжилгээ хийж, гаргасан дүгнэлт, зөвлөмжөө Улсын Их Хуралд хүргүүлж, нийтэд мэдээлнэ.

6.3. Зөвлөл төсвийн дунд хугацааны таамаглалын тайлан, төсвийн тогтвортой байдлын болон эрсдэлийн тайлан, бодлогын нөлөөллийн шинжилгээний тайланг гаргаж хуралдаанаараа хэлэлцэн, Улсын Их Хуралд танилцуулж, нийтэд мэдээлэх ба хагас жил тутам олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулна.

6.4. Зөвлөл хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг жил тутам Улсын Их Хуралд хүргүүлнэ.

6.5. Зөвлөл өөрийн үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд ил тод мэдээлнэ.

Долоо. Зөвлөлийн дотоод мэдээллийн нууцыг хадгалах

7.1. Зөвлөлийн үйл ажиллагааны дүрэмд зааснаас бусад тохиолдолд Зөвлөлийн гишүүн болон Төсвийн судалгааны нэгжийн ажилтан Зөвлөлийн дотоод мэдээлэл гэж тогтоосон, нийтэд зориулагдаагүй мэдээг тараах, бусдад мэдээлэх, хувийн зорилгодоо ашиглахыг хориглоно.